



**Арилжааны мэдээ**

- 2018 оны 23 дахь долоо хоногт Монголын хөрөнгийн биржээр нийт 2.43 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа явагдаж, зах зээлийн үнэлгээ 2.82 их наяд төгрөгт хүрлээ.
- Тус долоо хоногт MSE Top-20 индекс 2.01% буурч 19,622.29 нэгжид хүрсэн бол MSE I индекс 2.12% буурч 9,471.75 нэгж, MSE II индекс 2.34% буурч 9,829.04 нэгжид тус тус хүрлээ.
- Нийт 47 компанийн 5,908,230 ширхэг хувьцаа 2,172,719,549 төгрөгөөр арилжаалагдсан байна.
- Хамгийн их өсөлттэй хувьцаагаар Шивээ Овоо (SHV) 74.78% өсч 4,263 төгрөг, Хөвсгөл алтан дуулга (ADU) 14.99% өсч 141.5 төгрөгт тус тус хүрч хаагдлаа.
- Хамгийн их бууралттай хувьцаагаар Э-транс ложистикс (ETR) 17.65% буурч 70 төгрөг, Материал импекс (MIE) 17.65% буурч 9,000 төгрөгт хүрч хаагдлаа.

MSE Top 20 индекс

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа

Эх сурвалж: Монгол Банк

| | USD/MNT ханш | % Өөрчлөлт |
|-----|--------------|------------|
| USD | 2,412.80 | 0.12 |

Тодруулга

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.

Зах зээлийн өөрчлөлт

| Индекс | Нэгж | % Өөрчлөлт |
|-------------------|-----------|------------|
| MSE Top-20 индекс | 19,622.29 | 2.01% |
| MSE I индекс | 9,471.75 | 2.12% |
| MSE II индекс | 9,829.04 | 2.34% |

| Зах зээлийн хураангуй | Нийт (MNT) |
|-----------------------|-------------------|
| Зах зээлийн үнэлгээ | 2,427,288,845,158 |
| Арилжигдсан үнийн дүн | 2,282,006,467 |

| Үнийн дүнгээр | Хаалт (MNT) | Мөнгөн дүн |
|---------------------|-------------|-------------|
| ШИВЭЭ ОВОО | 2,050 | 954,777,910 |
| ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП | 300 | 546,801,900 |
| МОНГОЛ БАЗАЛЫТ | 390.7 | 322,685,128 |
| ЛэндМН ББСБ | 55.94 | 139,386,150 |
| ТАВАН ТОЛГОЙ | 9,900 | 99,131,030 |

| Тоо ширхэгээр | Хаалт (MNT) | Нийт |
|---------------------|-------------|-----------|
| ЛэндМН ББСБ | 55.94 | 2,552,346 |
| ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП | 300 | 1,822,673 |
| МОНГОЛ БАЗАЛЫТ | 390.7 | 809,262 |
| ШИВЭЭ ОВОО | 2,050 | 465,628 |
| АПУ | 587.25 | 160,162 |

| Ханш өссөн | Хаалт (MNT) | % Өөрчлөлт |
|----------------------|-------------|------------|
| АЛТАЙН ЗАМ | 4,263 | 74.78 |
| ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА | 141.5 | 14.99 |
| БЭРХ УУЛ | 964 | 14.90 |
| ЛэндМН ББСБ | 55.94 | 9.24 |
| ШАРЫН ГОЛ | 2,250 | 2.13 |

| Ханш буурсан | Хаалт (MNT) | % Өөрчлөлт |
|---------------------|-------------|------------|
| Э-ТРАНС ЛОЖИСТИКС | 70 | 17.65 |
| МАТЕРИАЛ ИМПЕКС | 9,000 | 17.58 |
| ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП | 300 | 13.65 |
| ХАЙ БИ ОЙЛ | 58 | 13.43 |
| ОЛЛОО | 60.1 | 10.29 |

| ЗЗҮнэлгээ өндөр | Хаалт (MNT) | Тэрбум/₮ |
|-----------------|-------------|----------|
| АПУ | 587.25 | 624.94 |
| ТАВАН ТОЛГОЙ | 9,900 | 521.39 |
| МИК ХОЛДИНГ | 10,500 | 217.45 |
| ГОВЬ | 22,580 | 176.15 |
| СҮҮ | 222.23 | 76.45 |

Дараах link-ээр орж арилжааг харна уу: <http://bdsec.mn/trade/>

**ЭНЭ ДОЛОО ХОНОГТ****“МОНГОЛ ШИР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**
(mse.mn)

- “Монгол шир” ХК-ийн 2017 оны 12 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох тухай шийдвэр гаргасныг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хороо “Монгол Шир” ХК-ийг үнэт цаасны бүртгэлээс хассан тул хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй эсхүл энэхүү шийдвэрийн эсрэг саналтай байсан саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдэд дараах эрх үүсэнийг мэдэгдэж байна. Үүнд:
“Монгол шир” ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж байгаа хувьцааг нэг бүрийг нь 2714 /хоёр мянга долоон зуун арван дөрөв/ төгрөгөөр эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн харьяа гишүүн үнэт цаасны компани эсвэл “БидиСЕК ҮЦК” ХК болон “Монгол шир” ХК-д хандана уу.
- Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг авалгүйгээр компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргах эрхтэй.
- Шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа: 2018 оны 7-р сарын 24-ний өдөр
- Дэлгэрэнгүй мэдээллийг 11-313108, 11-321763 утсаар лавлаж асууна уу

НҮҮРСНИЙ ҮНИЙГ ХЯЗГААРЛАХ БНХАУ-ЫН БОДЛОГО ҮР ДҮНГЭЭ
ӨГӨХГҮЙ БАЙНА (bloombergtv.mn)

- Тасралтгүй нэмэгдэж байгаа нүүрсний үнийг өсгөхгүй байх БНХАУ-ын Засгийн газрын бодлого тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Чинхуандаогийн боомтод нүүрсний үнийг 89 ам.доллар буюу 570 юань байх нь хамгийн тохиромжтой түвшин гэж тус улсын Засгийн газар үзэж байгаа аж. Хэдий тийм боловч одоогоор энэ түвшнээс 100 гаруй юаниар өндөр байгаа юм. Чинхуандаогийн боомтод зургаадугаар сарын дөрвөнөөр эцэслэсэн долоо хоногт нүүрсний спот ханш 4.2 хувиар өсөж, 667 юаньд хүрчээ. Энэ нь гуравдугаар сараас хойших хамгийн өндөр түвшинд тооцогдож байгаа бөгөөд тавдугаар сард нүүрсний эрэлт нэмэгдэж, агуулах дахь нөөцийн хэмжээ түүхэн доод түвшинд хүрсэнтэй холбоотой гэдгийг “Daiwa Capital Markets”-ийн шинжээчид онцолж байна.

“ШИВЭЭ-ОВОО”-Г ТҮШИГЛЭН 270 МВТ ЦАХИЛГААН СТАНЦ БАРИНА
(gogo.mn)

- Өмнө бүсийн эрчим хүчээр хангах томоохон төслийг БНСУ, АНУ, БНХАУ-ын хамтарсан мэргэжлийн компаниудтай эхлүүлэхээр болж, хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа. Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн 270мв цахилгаан станцыг барих юм.
- Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн цахилгаан станц барих талаар ярьж, үе үеийн Засгийн газар, УИХ-ыг дамжсан ч ажил хэрэг болж чадалгүй өдий хүрсэн. Харин өнөөдөр төр засаг өргөн цар хүрээтэй бодлогоор дэмжвэл Шивээ-Овоод цахилгаан станц босгоход ямар ч саад байхгүй гэдгийг хөрөнгө оруулагч компаниудын төлөөлөл хэллээ.
- Төслийн нээлтэд АНУ, БНСУ-ын эрчим хүчний компаниуд, БНХАУ-ын төрийн өмчит даатгалын компанийн төлөөлөл оролцов.
- Монголын талаас УУХҮЯ, Эрчим хүчний яам зэрэг төрийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд хүрэлцэн ирсэн юм. Тэд говийн бүсэд дэд бүтэц хамгийн тулгамдсан сэдэв гэдгийг онцлоод, хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, төр бодлогоор дэмжих учиртайг хэллээ.
- Энэ төсөл амжилттай болвол Налайх зэрэг дагуул хот болох шаардлагатай, алслагдсан газарт шинээр цахилгаан станц барьж, юун түрүүнд суурь дэд бүтцээ хөгжүүлэх шаардлагатайг Налайх дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазар онцлолоо.

“ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН” МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭГДЛЭЭ (bdsec.mn)

- 2018 оны 06 сарын 04-ний өдөр “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн Монголын Хөрөнгийн Биржид хувьцаагаа бүртгүүлэх, гэрээ байгуулах нээлтийн ёслолын арга хэмжээ МХБ дээр боллоо.
- Арга хэмжээний үеэр Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яамны сайд Д.Сумъяабазар, СЗХ-ны Дарга С.Даваасүрэн, “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн Гүйцэтгэх захирал Петер Акерли, Тэргүүлэгч андеррайтер “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн, Хамтрагч андеррайтер “Голомт Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Амарбаясгалан нар үг хэлж арилжааг нээн цан цохисон юм.

Компанийн тухай

- “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” нь Канад улсын хууль тогтоомжийн дагуу 2000 оны 7 сарын 14-нд байгуулагдан, Монгол Улсад ашигт малтмалын ордын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг 2002 оноос эрхэлж эхэлсэн.
- Голлох үйл ажиллагаа нь өндөр агууламж бүхий томоохон алт болон алт-зэсийн ордуудыг бага зардлаар нээн илрүүлэхэд төвлөрдөг. Оюу толгой төслийн алт, зэсийн ордуудыг багтаадаг чулуулгийн бүстэй ижил геологийн бүтэц бүхий газар нутагт хийсэн хайгуулын ажил нь ихээхэн амжилттай болж, компанийн эзэмшдэг 4 хайгуулын тусгай зөвшөөрлөөс 2 тусгай зөвшөөрлийн талбайд 7 алт болон зэсийн хуримтлалтыг нээн илрүүлснээс Баян Хөндий болон Алтан Нар төслүүдэд эцсийн шатны өрөмдлөг болон судалгааны ажлууд хийгдэж, олборлолтын шатруу ойртож байна.

Хувьцааны мэдээлэл

- 2004 оноос эхлэн ТОРОНТОГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖ дээр хувьцаа нь арилжаалагдаж эхэлсэн бөгөөд МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ дээр давхар бүртгүүлэн олон нийтэд хувьцаагаа санал болгож байна.
- ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ ЭРДЭНЭ РЕСУРС
- Үнэт цаасны төрөл: Энгийн хувьцаа
- МХБ-ийн бүртгэл: Давхар бүртгэл /Cross-listing/
- МХБ-ийн бүртгэлийн ангилал: III ангилал
- Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ: 640 төгрөг
- МХБ-д бүртгүүлэх хувьцааны тоо, төрөл: 4,000,000 ширхэг, энгийн хувьцаа
- Нийт үнийн дүн: 2,560,000,000 төгрөг
- Үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгыг **ЭНД ДАРЖ** үзнэ үү.

ХЯТАДЫН НҮҮРС ТЭЭВРИЙН ХҮНД ДААЦЫН ТӨМӨР ЗАМЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛНА (mtz.mn)

- Дэлхийн хамгийн урт хүнд даацын төмөр зам болох “Менхуа” төмөр замын нийт урт 1814.5 км бөгөөд уг замыг нүүрс тээвэрлэх зориулалтаар барьж байгуулж байна. Уг төмөр замыг III, IV зэрэглэлээр барьж, 2019 онд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ.
- БНХАУ-ын төмөр замын газрын мэдээлснээр Хятадын нүүрс олборлолт болон ханган нийлүүлэлтийг бүрэн хангахуйц стратегийн онцгой ач холбогдол бүхий энэхүү төмөр зам ашиглалтад орсоноор нүүрсийг “баруунаас зүүн, хойноос урагш” тээвэрлэх боломж бүрдэх ба жилийн нийт нэвтрүүлэх хүчин чадал 200 сая тонн байх юм.



БИДИСЕК ХК

О.Уранбайгал

Харилцагчийн албаны менежер
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-11-313108
Факс: 976-11-321763

Б.Билгүүн

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: bilguun@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-11-313108
Факс: 976-11-321763

Э.Алтансүх

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: darkhan@bdsec.mn

БиДиСек Дархан

Дархан-Уул аймаг, Монгол улс
Утас: +976-94082846

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.